



Н

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 39

Мандалговь

Үндсэн хөрөнгө дуудлагаар худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 20,000,000 /хорин сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй УАЗ-390942-018 маркын 73-75 ДУА улсын дугаартай автомашиныг актлан нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах доод үнийн хязгаарыг 5,000,000 /таван сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Уганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Ц.Дуламсүрэнд даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



480219101